



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 10 өдөр

Дугаар А/672

Ховд

Цэцэрлэгийн барилга /Ховд, Жаргалант сум, Баатархайрхан баг, 10 дугаар цэцэрлэг/-н ажилд дүгнэлт гаргах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4-ийн "а", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар "Турлиахт" ХХК-ийн хийж гүйцэтгэсэн Цэцэрлэгийн барилга /Ховд, Жаргалант сум, Баатархайрхан баг, 10 дугаар цэцэрлэг/-н ажилд ажлын тоо хэмжээнд тусгагдаагүй нэмэлтээр хийгдсэн ажлыг нягтлан шалгаж, нэмэлт гэрээ байгуулан санхүүжилтийг шийдвэрлэх боломжтой эсэх талаар шийдвэр гаргах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч: Б.Баярсүх

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого,  
төлөвлөлтийн хэлтсийн дарга

Гишүүд: Н.Ганзориг

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Б.Түмэндэмбэрэл - Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого,  
төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Б.Туулайтулга - Жаргалант сумын Засаг даргын орлогч

Т.Өлзийбаяр - 10 дугаар цэцэрлэгийн эрхлэгч

Д.Лхамсүрэн - "Турлиахт" ХХК-ийн захирал

Нарийн бичгийн

дарга: Б.Жамбалдорж

- Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын  
газрын мэргэжилтэн

2. Тус ажлыг шийдвэрлэх боломжтой эсэх талаар ажлын хэсгийн дүгнэлтийг гаргаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Баярсүх/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН  
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН

02-4112  
Zah A/672 Kh